



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг хоёрдугаар, "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж ажиллах, жагсаалтад тусгагдсан лабораторийн шинжилгээнд гадаад хяналт хийх лавлагаа лабораторийн жагсаалтыг батлуулахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Ж.Нарангэрэл)-т, эрүүл мэндийн урьдчилан үзлэг шинжилгээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагыг хамруулах тухай журмыг шинэчилж, хэрэгжилтэд хяналт тавьж аргазүйгээр хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Буянтогтох)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Жагсаалт, журам батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/470, 2016 оны А/228, 2020 оны А/436 дугаар тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.



С.ЭНХБОЛД

141213552

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02
дугаар сарын 18-ны өдрийн 111 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй
тусламж, үйлчилгээний журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь эрүүл мэндийн байгууллага /цаашид эрүүл мэндийн байгууллага гэх/-аас Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тус тус заасан улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгч (иргэн, аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн байгууллага)-ийн хүсэлтээр үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү тушаалын зорилго нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод туссан эрүүл мэндийн салбарын нийт зардалд иргэний шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг 25 хувиас хэтрүүлэхгүй байх, иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа шууд төлж буй төлбөрөөс үүдэлтэй санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлэхэд оршино.
- 1.3. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасан эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамаарч үзүүлэх бөгөөд энэхүү журамд хамаарахгүй.
- 1.4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 1.5. Төлбөртэй тусламж, үйлчилгээ гэдэгт Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ болон Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй, үйлчлүүлэгчийн хүсэлтээр эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх энэхүү тушаалын хоёр болон гуравдугаар хавсралтад заасан тусламж, үйлчилгээ хамаарна.
- 1.6. Бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хангах, туслах үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээ энэ тушаалын гуравдугаар хавсралтад хамаарна.

1.7. Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд тухайн гэрээ байгуулсан тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Тусламж, үйлчилгээний зохицуулалт

2.1. Эрүүл мэндийн байгууллага төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлэхэд байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй, мөн үйлчлүүлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр зохицуулах арга хэмжээг авна.

2.2 Лавлагаа лабораторид хийлгэх эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх лабораторийн тусламж, үйлчилгээний гадаад хяналтыг багцын тарифыг энэхүү тушаалын хавсралтаар баталсан шинжилгээ бүрийн төлбөрийн жишиг хэмжээг баримтлан байгууллага хоорондын гэрээгээр зохицуулна.

2.3 Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтын төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын 722-726-д заасан урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөөтэй холбоотой тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн үзүүлнэ.

2.4 Эрүүл мэндийн байгууллага үйлчлүүлэгчийн хүсэлтээр тухайн хэвтэн эмчлүүлж буй өвчний онцлогт тохирсон захиалгат эмчилгээний хоолоор үйлчилж болно.

2.5 Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн нийт батлагдсан орны 15%-иас хэтрэхгүйгээр иргэний хүсэлтийн дагуу тав тух хангасан төлбөртэй өрөөг ажиллуулж болох бөгөөд тасгуудад жигд хуваарилж, үйлчлүүлэгчид сонголтыг бий болгож, зохицуулалтыг хийнэ.

2.6 Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж олсон орлого нь тухайн эрүүл мэндийн байгууллагын жилийн нийт төсвийн 5 хувиас ихгүй байна.

2.7 Гадаадын иргэнд Олон улсын гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал

3.1 Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийг төлбөртэй тусламж, үйлчилгээнээс хөнгөлөх нөхцөл болон санхүүгийн дэмжлэг, туслалцаа авах бусад боломжийн талаар ил тод мэдээллээр хангаж, үйлчлүүлэгчийг албан бус төлбөр төлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

3.2 Эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын цахим хуудсанд байрлуулна. Үүнд:

3.2.1 Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ;

3.2.2 Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл;

3.2.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, оношийн бүлэг тус бүрээр даатгалын сангаас олгож буй санхүүжилтийн хэмжээ, даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ.

3.3 Иргэнээс энэхүү тушаалын хавсралтад заасан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг авахдаа улсын төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэхгүй байгаа шалтгааныг тайлбарлаж, иргэн зөвшөөрсний үндсэн дээр төлбөр авна.

Дөрөв. Хориглох зүйл

4.1 Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо, шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, материал, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй. Даатгуулагчийн хариуцан төлөх хамтын төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

4.2 Эрүүл мэндийн байгууллагууд энэхүү тушаалын хавсралтуудад заагдсан тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, шинжилгээний хариу өгөх зэрэг нийтлэг үйлчилгээ хамаарна. Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй.

4.3 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, асаргаа, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

4.5 Эрүүл мэндийн байгууллага энэхүү журмын хавсралтад заагдсан тусламж, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг өргөтгөх замаар үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого нэмэгдүүлэх эх үүсвэр болгохыг хориглоно.

Тав. Бусад

5.1 Үйлчлүүлэгч эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

5.2 Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалын хоёр болон гуравдугаар хавсралтаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж,

үйлчилгээнээс төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцно.

5.3 Энэхүү тушаалын хоёр болон гуравдугаар хавсралтаар баталсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирлын тушаалаар батлахгүй бөгөөд зайлшгүй шаардлагаар шинэ технологи, хөрөнгө оруулалтаар хийгдсэн тусламж, үйлчилгээ нэмэгдэх бол Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох мэдээллийг албан бичгээр ирүүлж, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.4 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, цалин, хөлс, урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын нөлөөллийг тооцож Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухай бүр шинэчилж мөрдөнө.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02
дугаар сарын 18-ны өдрийн 11/1 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй
тусламж, үйлчилгээний жагсаалт**

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код
1	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Микобактери илрүүлэх болон РИФ тэсвэржилт тодорхойлох	10101001
2	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Мөөгөнцөр илрүүлэх	10101002
3	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (шарх, хамар, хамар залгиур, залгиур, чих, нүд, умайн хүзүү, шээсний сүв, үтрээ, өтгөн, идээ, буглаа, цэр, шээс, гуурсны арчдас (трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс), хатгалтын шингэн, цэр бронхийн угаадасны нян судлалын шинжилгээ (хэвлий, плевр, тархи нугасны шингэн, үений шингэн, олгой цөс))	10101003
4	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Нян тээгчийн шинжилгээ	10101004
5	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх- Граммын будгийн арга	10101005
6	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Хүчилд тэсвэртэй нян өсгөвөрлөх	10101006
7	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Хүчилд тэсвэртэй нян илрүүлэх түрхэцийн шинжилгээ	10101007
8	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Цуснаас бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ	10101008
9	Лабораторийн шинжилгээ	Биохимийн шинжилгээ	NH3	10102001
10	Лабораторийн шинжилгээ	Биохимийн шинжилгээ	Trans-tubular potassium gradient	10102002
11	Лабораторийн шинжилгээ	Биохимийн шинжилгээ	АЛАТ	10102003
12	Лабораторийн шинжилгээ	Биохимийн шинжилгээ	Альбумин	10102004

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02
дугаар сарын 28-ны өдрийн 117/2 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

**Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл
мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх
төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт**

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код
763	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-A титр	20105001
764	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-B титр	20105002
765	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-D титр	20105003
766	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Кумбсын шууд бус урвалын шинжилгээ	20105004
767	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Кумбсын шууд урвалын шинжилгээ	20105005
768	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Резусын дэд бүлэг тодорхойлох	20105006
769	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Сөрөг Резус Д баталгаажуулах	20105007
770	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Улаан эсийн эсрэг бие илрүүлэлт	20105008
771	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Улаан эсийн эсрэг бие ялган дүйлт	20105009
772	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны бүлэг хувийн тохирооны чанарын гадаад үнэлгээний багц	20105010
773	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны бүлэг, резус	20105011
774	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны резус бүлэг тодорхойлох (Rh фактор), баталгаажуулах	20105012
775	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны хувийн тохироо /Картаар/	20105013
776	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Эргэлзээтэй бүлэг тодорхойлох	20105014
777	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны хувийн тохироо /Хуруу шилний аргаар/	20105015

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код
778	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Келл бүлэг тодорхойлох /Тавиур шил/	20105016
779	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Келл бүлэг тодорхойлох /Хуруун шил/	20105017
780	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Нярайн бүлэг, резус тодорхойлох	20105018
781	Цөмийн анагаах ухааны тусламж, үйлчилгээ	ПЕТ-КТ шинжилгээ	Цацраг идэвхт эм 18F-FDG	20201001
782	Эмгэг судлалын шинжилгээ	Дархлаа гистохимийн (Иммуногистохими) ялган оношилгоо хийж, дүгнэлт өгөх	Иммуногистохимийн шинжилгээ хийх (1 маркерийн үнэлгээ)	20301001
783	Эмгэг судлалын шинжилгээ	Эмгэг судлалын задлан шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Хувийн эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр хийлгэх эмгэг судлалын задлан шинжилгээ хийх	20302001
784	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд)	20303001
785	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (ясны эд)	20303002
786	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эсийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	20303003
787	Эмгэг судлалын шинжилгээ	Мэс заслын дараах эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (мэс ажилбараар авсан эд)	20304001
788	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Арьсны эдийн шинжилгээ авах, шууд тархан туяарах будгийн аргаар эдийг бэлтгэх	20305001
789	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Иммуногистохимийн шинжилгээ хийх	20305002
790	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ хийх FNA	20305003
791	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Үений шингэний шинжилгээ	20305004
792	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторид шинжлэх (эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	20305005

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код
793	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-К сийвэн	20401001
794	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Криопреципитат	20401002
795	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Нэгтгэж савласан криопреципитат	20401003
796	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 4 нэгж	20401004
797	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж,	20401005
798	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401006
799	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	Ст-Стандарт улаан эс	20401007
800	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Хөлдөөсөн шинэ сийвэн	20401008
801	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ХШС	20401009
802	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэн /хүүхэд 50 мл/	20401010
803	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	SARS-CoV-2 Эсрэг бие агуулсан хөлдөөсөн шинэ сийвэн	20401011
804	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	SARS-CoV-2 Эсрэг бие агуулсан эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн сийвэн	20401012
805	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Бүхэл цус	20401013
806	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Даршилсан улаан эс	20401014
807	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан ДУЭ	20401015
808	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан ЦЭДУЭ	20401016

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код
809	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан ЦЭУЭӨ	20401017
810	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан улаан эсийн өтгөрүүлэг	20401018
811	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан угаасан улаан эс	20401019
812	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан цагаан эсгүйжүүлсэн бүхэл цус	20401020
813	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Угаасан улаан эс	20401021
814	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Гэсгээж угаасан улаан эс	20401022
815	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Цагаан эсгүйжүүлсэн бүхэл цус	20401023
816	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан бүхэл цус	20401024
817	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Улаан эсийн өтгөрүүлэг	20401025
818	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Цагаан эсгүйжүүлсэн даршилсан улаан эс	20401026
819	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн өтгөрүүлэг	20401027
820	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	Резусийн фенотип /CcEe/ тохирсон, хувийн тохироотой улаан эс	20401028
821	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ -ялтаст эсийн өтгөрүүлэг	20401029
822	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ -ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401030
823	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Нэгтгэж савласан ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401031
824	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Нэгтгэж савласан ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401032

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код
825	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ЯЭӨ (Бүхэл цус)	20401033
826	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 4 нэгж	20401034
827	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж,	20401035
828	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401036
829	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ЯЭӨ (Цитоферез)	20401037
830	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 5 нэгж	20401038
831	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401039
832	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401040
833	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Туяагаар шарсан,Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 5 нэгж	20401041
834	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Туяагаар шарсан,Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401042
835	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Туяагаар шарсан,Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401043
836	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Цитоферезээр бэлдсэн эмгэгтөрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг	20401044
837	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Цитоферезээр бэлдсэн туяагаар шарсан эмгэгтөрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг	20401045
838	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Цитоферезээр бэлдсэн ЯЭӨ	20401046
839	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Хүчилтөрөгч - 40 литр баллон	20402001
840	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Иммуноглобулин 1.5 мл	20402002

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны ⁰⁴ дугаар
сарын ⁰⁸ -ны өдөр

Дугаар 49/А/18

Улаанбаатар хот

ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ" - г нэгдүгээр, "Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг мөрдөж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг холбогдох журмын дагуу санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх орлогыг жил бүрийн төсөвт хянаж тусгахыг Эрүүл

мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар (Б.Мөнхтуул), тушаалын хэрэгжилтэд
хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар
(Б.Буянтогтох), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т
тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Төлбөрийн жишиг хэмжээ,
журам батлах тухай” Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264/А/293
дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
763	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-A титр	20105001	30,000
764	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-B титр	20105002	30,000
765	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-D титр	20105003	30,000
766	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Кумбсын шууд бус урвалын шинжилгээ	20105004	23,000
767	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Кумбсын шууд урвалын шинжилгээ	20105005	23,000
768	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Резусын дэд бүлэг тодорхойлох	20105006	30,000
769	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Серег Резус Д баталгаажуулах	20105007	10,000
770	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Улаан эсийн эсрэг бие илрүүлэлт	20105008	28,000
771	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Улаан эсийн эсрэг бие ялган дүйлт	20105009	28,000
772	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны бүлэг хувийн тохирооны чанарын гадаад үнэлгээний багц	20105010	63,000
773	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны бүлэг, резус	20105011	8,000
774	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны резус бүлэг тодорхойлох (Rh фактор), баталгаажуулах	20105012	7,000
775	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны хувийн тохироо /Картаар/	20105013	15,000
776	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Эргэлзээтэй бүлэг тодорхойлох	20105014	11,000

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
777	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны хувийн тохироо /Хуруу шилний аргаар/	20105015	39,000
778	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Келл бүлэг тодорхойлох /Гавиур шил/	20105016	8,000
779	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Келл бүлэг тодорхойлох /Хуруун шил/	20105017	39,000
780	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Нярайн бүлэг, резус тодорхойлох	20105018	17,000
781	Цөмийн анагаах ухааны тусламж, үйлчилгээ	ПЕТ-КТ шинжилгээ	Цацраг идэвхт эм 18F-FDG	20201001	900,000
782	Эмгэг судлалын шинжилгээ	Дархлаа гистохимийн (Иммуногистохими) ялган оношилгоо хийж, дүгнэлт өгөх	Иммуногистохимийн шинжилгээ хийх (1 маркерийн үнэлгээ)	20301001	131,000
783	Эмгэг судлалын шинжилгээ	Эмгэг судлалын задлан шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Хувийн эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр хийлгэх эмгэг судлалын задлан шинжилгээ хийх	20302001	702,000
784	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд)	20303001	40,000
785	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (ясны эд)	20303002	66,000
786	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эсийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	20303003	106,000

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт онош тавьж, дүгнэлт өгөх	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
787	Эмгэг судлалын шинжилгээ	Мэс заслын дараах эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (мэс ажилбараар авсан эд)	20304001	79,000
788	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Арьсны эдийн шинжилгээ авах, шууд тархан туяарах бүдгийн аргаар эдийг бэлтгэх	20305001	60,000
789	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Иммуногистохимийн шинжилгээ хийх	20305002	150,000
790	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ хийх FNA	20305003	50,000
791	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Үений шингэний шинжилгээ	20305004	33,000
792	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторид шинжлэх (эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	20305005	48,000
793	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	C-K сийвэн	20401001	70,000
794	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	C-Криопреципитат	20401002	35,000
795	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	C-Нэгтгэж савласан криопреципитат	20401003	300,000
796	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 4 нэгж	20401004	63,000

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
797	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж,	20401005	126,000
798	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401006	157,500
799	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	Ст-Стандарт улаан эс	20401007	25,000
800	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Хөлдөөсөн шинэ сийвэн	20401008	115,000
801	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ХШС	20401009	170,000
802	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	С-Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэн /хүүхэд 50 мл/	20401010	44,000
803	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	SARS-CoV-2 Эсрэг бие агуулсан хөлдөөсөн шинэ сийвэн	20401011	145,000
804	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	SARS-CoV-2 Эсрэг бие агуулсан эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн сийвэн	20401012	200,000
805	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Бүхэл цус	20401013	102,000
806	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Даршилсан улаан эс	20401014	110,000
807	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан ДУЭ	20401015	115,000

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
808	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан ЦЭДУЭ	20401016	150,000
809	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан ЦЭУЭӨ	20401017	150,000
810	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан улаан эсийн өтгөрүүлэг	20401018	120,000
811	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан угаасан улаан эс	20401019	135,000
812	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан цагаан эсгүйжүүлсэн бүхэл цус	20401020	135,000
813	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Угаасан улаан эс	20401021	130,000
814	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Гэсгээж угаасан улаан эс	20401022	450,000
815	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Цагаан эсгүйжүүлсэн бүхэл цус	20401023	130,000
816	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Туяагаар шарсан бүхэл цус	20401024	110,000
817	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Улаан эсийн өтгөрүүлэг	20401025	115,000
818	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Цагаан эсгүйжүүлсэн даршилсан улаан эс	20401026	145,000

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
819	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	УЭ-Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн өтгөрүүлэг	20401027	145,000
820	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	Резусийн фенотип /CcEe/ тохирсон, хувийн тохиоотой улаан эс	20401028	180,000
821	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ -ялтаст эсийн өтгөрүүлэг	20401029	25,000
822	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ -ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401030	90,000
823	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Нэгтгэж савласан ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401031	130,000
824	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Нэгтгэж савласан ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401032	160,000
825	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ЯЭӨ (Бүхэл цус)	20401033	30,000
826	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 4 нэгж	20401034	95,000
827	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж,	20401035	135,000
828	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401036	165,000
829	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Туяагаар шарсан ЯЭӨ (Цитоферез)	20401037	450,000

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
830	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 5 нэгж	20401038	430,000
831	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401039	450,000
832	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401040	490,000
833	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Туягаар шарсан, Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 5 нэгж	20401041	435,000
834	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Туягаар шарсан, Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 6 нэгж	20401042	455,000
835	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Туягаар шарсан, Эмгэг төрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 8 нэгж	20401043	495,000
836	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Цитоферезээр бэлдсэн эмгэгтөрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг	20401044	790,000
837	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ- Цитоферезээр бэлдсэн туягаар шарсан эмгэгтөрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг	20401045	795,000
838	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн цус сэлбэлтийн цогц тусламж үйлчилгээ	ЭБ-Цитоферезээр бэлдсэн ЯЭӨ	20401046	450,000
839	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Хүчилтөрөгч - 40 литр баллон	20402001	20,000
840	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Эмнэлзүйн бусад цогц тусламж, үйлчилгээ	Иммуноглобулин 1.5 мл	20402002	47,000

Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын
2022 оны 05 сарын 02 өдрийн 431/18 дугаар
хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

**“Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх
төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон
орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллага /цаашид эрүүл мэндийн байгууллага гэх/-аас үзүүлэх улсын төсвөөс хариуцах болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан төлбөрийн жишиг хэмжээ, жагсаалтад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй, код, ангиллыг өөрчлөхгүйгээр өөрийн байгууллагын үйлчилгээний хүрээнд тохируулан батална.

1.3. Нэмэлт тусламж, үйлчилгээ гэдэгт Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасныг тус тус ойлгоно.

1.4. Энэ журам нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 болон 15.2-т зааснаас бусад төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад хамаарна.

**Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон
орлогын бүртгэл, зарцуулалт**

2.1. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгаж Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын эрх үүргийн хүрээнд захиран зарцуулна.

2.2. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн

хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхтэй холбоотой гарах зардалд зарцуулна.

2.3. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллага нь тухайн жилийн төсөвт тусгагдаагүй, шинээр бий болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Төсвийн тухай хуулийн 46.2-т заасан журмын дагуу зарцуулж, тайлагнана.

2.4. Үйлчлүүлэгчийг байгууллагын кассаар эсвэл цахимаар төлбөр төлөх бүхий л төрлийн боломжоор хангаж төлбөрийг төрийн сан дахь төсвийн үндсэн үйл ажиллагааны дансанд төвлөрүүлнэ.

2.5. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана.

2.6. Эрүүл мэндийн байгууллага нь иргэнд төлбөр төлсөн баримтыг (и-баримт) заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн байгууллагын нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

2.7. Энэ журамд заасан төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогын зарцуулалтын жилийн эцсийн тайланг дараа жилийн төсвийн төсөлтэй хамт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Эмч, эмнэлгийн ажилтны хориглох зүйл

3.1.Эмч, эмнэлгийн ажилтанд дараах зүйлсийг хориглоно:

3.1.1. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэхгүй байх;

3.1.2. Эрүүл мэндийн байгууллагын ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэх;

3.1.3.Үйлчлүүлэгчээс эрүүл мэндийн байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр шилжүүлэхийг шаардах.

Дөрөв. Хяналт

4.1. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг

доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар хүлээнэ.

4.2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд эрүүл мэндийн байгууллагын дотоод аудитын нэгж улирал бүр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын нэгж жилд нэг удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

4.3. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг байгууллагын дарга, захирал нар хангаж ажиллана.

Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Иргэн эрүүл мэндийн байгууллагын нэмэлт үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

5.3. Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.

5.4. Энэ журмын 5.3-т зааснаар иргэний төлбөрийг барагдуулсан бол Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд зааснаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.